

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-12

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./	3-12
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 38 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Г.Тэмүүлэн, Н.Батсүмбэрэл, Э.Болормаа, Л.Гантөмөр, Б.Жаргалан, С.Лүндэг, Н.Наранбаатар, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар, Л.Энхнасан;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Анар, Б.Тулга.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Энхболд, мөн газрын Нийцлийн аудитын газрын захирал Б.Баттуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын мэргэжилтэн Р.Хангал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мөн хэлтсийн мэргэжилтэн О.Гантулга, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах шинжээч Н.Уранчимэг, Д.Отгонжаргал, ахлах мэргэжилтэн П.Энхманлай, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Тогтвортой хөгжил,

нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Урьболд, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, мөн штабын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга П.Эрдэнэбаяр, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Баянмөнх, Санхүү, ар талын газрын дарга Т.Мөнхдорж, Цөмийн энергийн комиссын ажлын албаны Тамгын газрын дарга Б.Баатарцогт, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 34 минут үргэлжилж, 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
12 цаг 38 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Гадаад бодлогын байнгын хорооны өнөөдрийн 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны ирц бүрдсэн тул нээснийг мэдэгдье.

Ирцийг би танилцуулъя. Ирц 51.7 хувьтайгаар бүрэлдсэн байна. Ингээд Очирбатын Амгаланбаатар гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүн гэсэн ийм ирцтэйгээр өнөөдрийн хуралдааны ирц бүрэлдсэн байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Ингээд Байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье. 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 1 асуудал байгаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд, Засгийн газар 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн гурав дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд бид хүргүүлнэ. Ингээд өнөөдөр энэ гурав дахь хэлэлцүүлгийг хийх гэж байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Тэгвэл хэлэлцэх асуудлыг баталлаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Өнөөдөр ажлын хэсэгт Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Цэдэнжав, тус газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Энхболд, Монгол Улсын Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал Баттуяа. Энэ Аудитын газраас.

Сангийн яамнаас Жавхлан сайд. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Санхүү төсвийн судалгааны газрын дарга Золбоо, Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал. Тус яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, Сангийн яамны төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Татварын ерөнхий газрын дарга Чимэдсүрэн гэсэн бүрэлдэхүүн байж байна. Сангийн яамнаас. Өшөө татварын газраас Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага арга зүйн газрын дарга Мягмаржав, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Уранцэцэг, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Отгонжаргал, тус яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Энхманлай, тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн Р.Хангал, тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн Гантулга гэсэн бүрэлдэхүүнтэйгээр Татварын газар, Сангийн яамнаас энэ системээс хүмүүс ирж оролцож байна.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас Учрал сайд, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү, яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Энх-Амгалан, яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Анар, яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Баясгалан, тус яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мөнхтөр, тус яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга Чандмань, тус яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Урьболд, тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Гэрэлбат гэсэн бүрэлдэхүүнтэйгээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас хүмүүс, төлөөлөл оролцож байна.

Батлан хамгаалах яамнаас сайд Батлут, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал Ганхуяг, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал Ганбямба, Зэвсэгт хүчний Жанжин штабын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа Эрдэнэбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр Батлан хамгаалах яамны төлөөлөл оролцож байна.

Гадаад харилцааны яамнаас сайд Батцэцэг, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг, тус яамны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Отгонцэцэг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр Гадаад яамнаас хүмүүс оролцож байна. Төлөөлөл.

Онцгой байдлын ерөнхий газраас тус газрын дарга, хошууч генерал Ариунбуян, тус газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Баянмөнх, тус газрын Санхүү, ар талын газрын дарга, хурандаа Мөнхдорж, Цөмийн энергийн комиссоос Цөмийн энергийн комисс Улсын ажлын албаны Тамгын газрын дарга Баатарцогт гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг өнөөдрийн хуралдаанд оролцож байна. Бүрэлдэхүүнийг танилцуулж дууслаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаарх

танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайд байна уу? Өөр тэгвэл танилцуулах сайд. Төрийн нарийн нь байж байвал танилцуулж байж болж л байна. Заавал сайд танилцуулах уу? Тэгвэл тэгээд хүлээе дээ сайдыг нь. Жавхлан сайд хаана сууж байгаа юм? Та ирцдээ орчихсон байгаа юу? Ер нь тэгэхдээ танд микрофон өгөхөд чинь хуруугаа уншуулахгүй бол. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулж, 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Ирэх 2026 оны төсвийн төслийг Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй уялдуулан боловсрууллаа. Төсвийн төсөлд туссан тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах онцлох арга хэмжээг дурдъя.

Нэгдүгээрт, төсвийн урсгал зардлын хувьд удирдах албан тушаалтны орон тоог бууруулж, төрийн албан хаагчдын нийт орон тооны тэлэлтийг хязгаарлахын зэрэгцээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн байгууллагын үр ашиггүй зардлыг бууруулан хэмнэгдсэн хөрөнгийг нийгмийн салбарт зарцуулах. Сүүлийн жилүүдэд гамшиг ослын тоо эрс нэмэгдэж, улсын хэмжээнд 2025 он гарсаар 15 аймгийн 74 сум нийслэлийн 3 дүүрэгт нийт 219 удаагийн ой хээрийн гал түймэр бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.4 дахин өссөн. Мөн үер, ус, ган зудын тохиолдол ихэссээр байна.

Иймд гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэхэд онцгой байдлын байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх, тус албанд ажиллах хүний нөөцийн бодлогод хөшүүрэг, дэмжлэг болгох зорилгоор албан хаагчдад олгодог онцгой нөхцөлийн нэмэгдлийг 10 хувиар нэмэгдүүлж, 40 хувьд хүргэх.

Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын 17 дугаар бага хурлыг 2026 онд Монгол Улсад зохион байгуулах болсонтой холбогдуулан хурлын бэлтгэл ажлыг хангах, улс орноо сурталчлан таниулах, мэдээлэл түгээх, дамжуулах, соёл урлагийн арга хэмжээ зохиох, олон улсын зочид, төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах, тав тухтай орчныг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг санхүүжүүлэх. Дэлхийн банкны аргачлалаар Монгол Улс 2024 оноос дунд оноос дунджаас дээгүүр орлоготой орны ангилалд орж тус ассоциацийн донор орнуудад гишүүнээр элсэх нөхцөлийг хангаад байгаа бөгөөд донор орон болохтой холбоотойгоор Олон улсын хөгжлийн ассоциацид хандив хэлбэрээр 5.5 тэрбум төгрөгийг олгохоор тус тус 2026 оны төсвийн төсөлд тусгалаа.

Хоёрдугаарт, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хуульд заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн иргэдээс санал авч, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн салбар яамны түвшинд үе шаттайгаар төлөвлөсөн.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр нийт 14.4 их наяд төгрөгийн санхүүжих дүн бүхий 1712 төслийн санал хүлээн авснаас холбогдох шалгуур үзүүлэлт, зарчим, бодлогыг харгалзан эрэмбэлж 579 төсөл,

арга хэмжээнд 3 их наяд 267.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхэд төсвийн төсөлд тусгасан болно.

Нийт хөрөнгө оруулалтын 67 хувь буюу 2 их наяд 181.9 тэрбум төгрөг нь үргэлжлэн хэрэгжих 33 хувь буюу 1 их наяд 85.5 тэрбум төгрөг нь шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт байна. Энэ нь 2022-2023 онд батлагдсан төслийн тоотой харьцуулахад 2 дахин буурсан үзүүлэлт бөгөөд төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх, шалгуур үзүүлэлтийн чанар сайжирч байгааг илтгэж байна.

Түүнчлэн 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтад хүний хөгжлийг дэмжих зорилгоор боловсрол, эрүүл мэндийн салбарт бүсчилсэн хөгжил болон хувийн хэвшлийг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулах хүрээнд эрчим хүч, суурь, дэд бүтцийн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулж, үндэсний сөрөн тэсвэрлэгдэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор онцгой байдлын салбарт нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах үүднээс батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбарт шинэ хөрөнгө оруулалтыг түлхүү төлөвлөлөө.

Тухайлбал, тус Байнгын хороонд хамаарах салбарууд буюу батлан хамгаалах салбарт 68 тэрбум төгрөг, гадаад харилцааны салбарт 20 тэрбум төгрөг, онцгой байдлын салбарт 40 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгалаа.

Мөн олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд НҮБ СОР-17 хурлыг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилт болон гадаад зээл, тусламжийн төслүүдийн Монголын талын хариуцах хөрөнгийг төсөвт тусгалаа.

Гуравдугаарт, Засгийн газрын өөрийн өрийн хувьд Улсын Их Хурлаас 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Засгийн газрын өрийн удирдлагын 2026-аас 28 оны стратегийн баримт бичгийг 4 зорилт, шалгуур үзүүлэлттэйгээр баталсан.

Засгийн газрын зүгээс дунд хугацааны стратегийн баримт бичгийн зорилт, арга хэмжээг мөрдөн шалгах, ажиллах бөгөөд 2026 онд Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх 1 тэрбум ам.доллар хүртэлх Засгийн газрын өрийн баталгаа гаргах, аймаг, нийслэлийн үнэт цаасыг зохистой хэмжээнд арилжаалах, дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих, суурь хүүг тогтоох зорилгоор 562 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас гаргах, дахин санхүүжүүлэх зорилгоор 1 тэрбум ам.доллар хүртэл гадаад үнэт цаас арилжаалахаар төсвийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн 2026 онд Засгийн газрын өрийн үйлчилгээний 3.9 их наяд төгрөг төлөхөөр байгаагаас үндсэн төлбөрт 2.6 их наяд төгрөг, хүүгийн төлбөрт 1.3 их наяд төгрөгийг төлөхөөр байна. Засгийн газрын өрийн нэрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 2025 онд 44.5, хувь, 2026 онд 43.7 хувьтай тэнцэхээр байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлага болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд туссан хязгаарыг хангахаар байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 31.6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь зарлага 29.6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн

суурь тэнцэл 2 их наяд төгрөгийн ашигтай төгрөгийн төгрөгийн ашигтай буюу ДНБ-ний 2 хувь байж, төсвийн тусгай 2 хувьд багтаж төсвийн тусгай шаардлагуудыг бүрэн хангаж байгаа.

Иймд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Цогтбаатар: Жавхлан сайдад баярлалаа.

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор болон төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд байгаа бол нэрсээ өгнө үү.

Бум-Очир гишүүнээр тасаллаа. Бум-Очир гишүүний микрофоныг өгье.

Д.Бум-Очир: Баярлалаа. Юуны өмнө би талархал илэрхийлэх гэсэн юм. Энэ бүх ажил бас явахгүй зогсчихдог, болохгүй бүтэхгүй байгаа юм биш юм байна. Та бүхэн санаж байгаа байх манайхан 3 жилийн өмнөөс ЮНЕСКО-гийн Ерөнхий ассамблей дээр нүүдэлчдийн түүх, соёл, иргэншлийн асуудлаар ном бичихээр ингээд Ерөнхий Ассамблейн хурлаар оруулаад шийдүүлчихсэн. Тэр мөнгөө төсөвтөө тавихгүй яваад 2, 3 жил болчихож байгаа тухай би чуулган дээр хэлж байсан. Байнгын хорооны хурал дээр мөн хэлж байсан. Тэгээд энийг манай Боловсрол, шинжлэх ухааны сайд байсан Лу.Энх-Амгалан гишүүн тухайн үедээ хөөцөлдөж бүтээж байсан. ЮНЕСКО-гийн Ерөнхий ассамблейн хурал дээр ингээд шийдүүлнэ гэдэг бол уул нь их бас чухал том ажил юм. Тэгээд энэ бүтэц энэ тэр өөрчлөгдөөд нөгөө мөнгө төгрөгөө суулгаж чадахгүй шинжлэх ухааны хэсэг нь Эдийн засаг, хөгжлийн яам руу яваад ингээд энэ мөнгө, энэ ажил замхрах маягтай болчихсон байсан ... үр дүнд бид сүүлийн хэдэн жил ЮНЕСКО-гийн нүүрийг харахад эвгүй болчихоод байсан тухай би хэлж байсан. Тэгээд энэ мөнгө маань нэгэнт эндээс бид юу харж байх болох вэ гэхээр энэ яамнуудын хооронд ингээд ажил төрлийн уялдаа холбоо муутай байгаад завсар нь ажлууд, чухал ажлууд хаягддаг тухай нэгдүгээрт бид нар эндээс харж болно.

Нөгөөдөх нь юу вэ гэхээр энэ төсвийн маань Гадаад хэргийн яам, Гадаад хэргийн сайд өөрийн салбарын төсөвтөө суулгаад шийдэхээр болж байгаад туйлын их баяртай байна. Энэ чиглэлээр судалгаа хийдэг, ажилладаг эрдэм шинжилгээний байгууллагууд бусад хүмүүсийнхээ өмнөөс онцгойлон Гадаад хэргийн сайд болоод энд Мөнхтүшиг Төрийн нарийн бичгийн дарга сууж байна. Та бүхэнд талархаж байгаагаа илэрхийлье. Бусад яамнууд маань ингэж сайхан ажилладаг болоосой, ингэж гишүүдийн хэлж байгааг ойлгодог, дэмждэг болоосой гэж бас чин сэтгэлээсээ хүсэж байна. Сангийн яамандаа бас талархаж байгаагаа хэлье. Гэхдээ энэ асуудлыг Сангийн яам гэхээсээ илүү Гадаад хэргийн яам бас шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн шүү Жавхлан сайд аа.

Тэгээд хамгийн гол нь би эндээс нэг зүйлийг хараад байгаа юм. Энэ асуудлуудаа бид нар бас ойлгуулж өгөх ёстой юм байна. Та бүхэн маань энэ болгоныг заавал ойлгож байх албагүй байх. Жишээ нь энэ нүүдлийн соёл иргэншлийн тухай асуудлыг би яриад байсан. Одоо энэ 11 сарын эхээр Узбекистаны Самарканд хотноо ЮНЕСКО-гийн Ерөнхий Ассамблейн хурал болох гэж байна. Манайхан оролцохоор явж байгаа. Тэгээд бас нүүр бардам хуралдаа

оролцохоор болж байгаа гэж энэ салбараа хариуцаж байгаа улсууд нь хэлж байна. Тэр хүмүүсийн бас талархаж байгаагаа илэрхийлмээр байгаа юм.

Энэ дээр би нэг зүйлийг яагаад ийм баяртай байгаагаа би бас тайлбарлах ёстой байх. Маш товчхон хэлчихье. Энэ бас олон нийтэд хэрэг болох болов уу гэж бодож байна. Энэ нүүдэлчдийн бүдүүлэг, зэрлэг, соёл иргэншил байгуулаагүй гэсэн ийм нийгмийн хувьчлалын онол гэдэг ийм онол байдаг юм аа. 1800 оны сүүл, 1900 оны эхэн үеэр гарч ирсэн. Харамсалтай нь энэ онол цаашаа өргөн хэмжээнд дэлгэрээд сүүлдээ миний яриад байдаг колоничлолын зэвсэг болсон, мэдлэгийн колоничлол болсон байхгүй юу. Тэгээд аваачаад энэ нүүдэлчид буюу бидний өвөг дээдсийг соёл иргэншил байгуулж байгаагүй юм шигээр ингэж дэлхий нийтээрээ ойлгодог болсон. Үүний эсрэг зөндөө олон эрдэмтэд, судлаачид дуугарсан боловчиг харамсалтай нь бас тэгж их дэлгэрээгүй. Үүнд хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн хүмүүс Монголчууд бид нар байхгүй юу эсэргүүцэхэд нь. Дэлхийн олон эрдэмтэд байгаа. Түүн дээр олон улсын байгууллагуудаас ЮНЕСКО байдаг юм. 1960-аад, 66 оны ЮНЕСКО-гийн ерөнхий бага хурал 14 дүгээр чуулганаар энэ Төв Азийн нүүдлийн соёл иргэншлийг судлах тухай судалгааны төслийг хэрэгжүүлж эхэлсэн. 1972 онд тухайн үеийн манай Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч ЮНЕСКО-гийн үндэсний комиссын дарга байсан Цэрэв гуай энэ Төв Азийн соёл иргэншил дэх нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүрэг гэдэг эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах санал гаргаад энэ хурал нь 1974 онд хийгдэж байсан. Өөрөөр хэлбэл энэ чиглэлд бидний өвөг дээдэс өмнөх улсууд маань онцгойлон хувь нэмэр оруулж ирсэн. Энэ байр сууриа бид олон нийтэд болоод дэлхий нийтэд хадгалж үлдэх ийм шаардлага байгаа юм.

Д.Цогтбаатар: Асуулт асуусангүй. Үг хэлчихлээ гэж ойлголоо. Тэгвэл Хосбаяр гишүүний микрофоныг өгье.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ төсвийг дагаж орж ирж байгаа хууль тогтоомжийн төсөл дээр Эрдэнэс Тавантолгойтой холбоотой хэсэг байгаа. Энэ дээр тухайлбал валютын орлогыг нэмэгдүүлэх, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор тухайлбал 1 тэрбум ам.доллар-ын үнийн дүнтэй 3-5 удаагийн том арилжааг зохион байгуулна. Энэ зохион байгуулагдсанаар дэнчин болон эхний төлбөрийн орлого ойролцоогоор 250-350 тэрбум доллар Монгол Улсад татан төвлөрүүлнэ гээд ингээд биччихсэн байх юм. Энэ алдаатай биччихсэн юм уу, эсвэл яг үнэхээр ингэж арилжаа зохион байгуулаад 250-350 тэрбум доллар орж ирэх гээд байгаа юм уу? Тэгээд энэ мөнгө татаж оруулж ирээд энэ мөнгөөрөө бас ер нь ямар чиглэлд зарцуулна, бүтээн байгуулалт хийх юм уу, эсвэл төсвийн зарлагын алдагдлаа нөхөх юм уу гээд олон асуулт гарах байх. Тэгэхээр энэ мөнгө, энэ арилжааг ер нь ямар утга агуулгаар зохион байгуулж, мөнгийг нь яаж зарцуулна гэж тооцож байгаа юм бол энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яам хэлж өгөөч.

Мөн энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж ирэх тогтоол бас дагаж орж ирж байгаа. Энэ дээр ер нь энэ өөрчлөлт хийгдсэнээр энэ гадаадын хөрөнгө оруулалттай Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн энэ ажилд оролцох боломж гарах уу? Одоо яг энэ үг, үсэг дээр айхтар тийм давуу байдал олгосон зүйл байхгүй байгаа. Гэхдээ ер нь цаашдаа энэ гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд Монгол Улсад ингээд хөрөнгө оруулалт хийхэд ямар дэмжлэг байхаар ингэж тусгах вэ? Ер нь бид нар энэ төсвийнхөө төсвийн төсөл дээрээ энэ хувийн хэвшил буюу энэ аж ахуйн нэгжүүдээ дэмжсэн ямаршуу заалт,

хөнгөлөлтүүдийг бас оруулж ирэх вэ? Нэг талд нь бид нар чинь цалин тэтгэврээ нэмье. Баахан л зардал нэмэх юм яриад байдаг.

Гэтэл нөгөө талд нь энэ орлогыг бүрдүүлдэг гол хэсэг болох хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдэд ерөөсөө ээлтэй ийм зүйл байхгүй байна л гэж харагдаад байна л даа. Тийм учраас энийгээ бас энэ Эдийн засаг, хөгжлийн яам сайн хэлмээр байна. Жишээ нь Хятадад гэхэд орон сууцын үнэ улирал улирлаар, сар сараар буурч байна. Бүтээн байгуулалтууд нь хумигдаж байна. Тэнд байгаа маш их туршлагатай компаниуд хөрөнгө мөнгөтэй компаниуд бүтээн байгуулалт том ажлууд ингээд хийе гээд гадагшаа л зах зээл сонирхож байх шиг байна л даа. Тэгээд тэд нар ингээд Монгол руу орж ирье гэхэд ер нь яг энэ төрийн хэвшлийн түншлэлийн хуулийн өөрчлөлтөөр боломж нээгдэх үү? Одоо бол ямар ч боломжгүй байгаа шүү дээ. 23 оноос хэрэгжиж эхэлсэн хуулиар 1 ч амжилттай хэрэгжсэн төр, хувийн хэвшлийн түншлэл байхгүй. Тэгэхээр дамаа энэ бүтээн байгуулалтын тал дээр энэ гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад давуу байдал олгох тийм зүйл байх уу? Энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яамныхан сайн хариулт хэлж өгөөч гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон. Хэн билээ өөрийгөө танилцуулаад хариулаарай.

Т.Баясгалан: Сайн байцгаана уу? Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Баясгалан байна. Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Сүүлийн асуултад нь хариулж байгаа шүү. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуультай холбогдуулж асуусан. Тэгэхээр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль мөрдөгдөж эхлээд яг жил 10 сарын хугацаа болж байгаа тэр үнэн. Энэ хугацаанд яг сая хамгийн сүүлд 8 сарын 27-ны өдөр Засгийн газрын хуралдаанаас Мөрөн-Улиастай чиглэлийн барих, ашиглах шилжүүлэх “Би Өү Ти” төрлөөр авто замын түншлэлийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр Засгийн газрын шийдвэр гарсан. Үүнтэй холбогдуулаад Эдийн засаг, хөгжлийн сайд, Зам, тээврийн сайдын хамтарсан тушаалаар төр, хувийн хэвшлийн хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах сонгон шалгаруулалтын ажлын хэсэг гарсан. Энэ сонгон шалгаруулалтыг зарлах гэж байна. Таны хэлж байгаа үнэн. Анх удаагаа яг энэ түншлэлээр хэрэгжих гэж байгаа эхний бүрэн шинжилгээ хийгдээд Засгийн газраас шийдвэр гарсан төслийг сонгон шалгаруулах процесс явж байна. Яг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан зохицуулалтаас харахад гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, дотоодын аж ахуйн нэгж энэ ямар нэгэн байдлаар компанийн ч бай энэ аж ахуйн нэгжийн хэлбэр, төрлөөсөө үл хамаараад хуулийн зохицуулалт ижил үйлчилж байгаа. Ямар нэгэн байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид яг энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар давуу байдал олгох байдаг юм уу, дотоодын аж ахуйн нэгжийг ингэж үзнэ ч гэдэг юм уу иймэрхүү зохицуулалт байхгүй. Түншлэгч хувийн хэвшлийн түншлэгч гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж ч байж болно. Мөн дотоодын Монгол Улсын аж ахуйн нэгж ч байж болохоор ийм зохицуулалттай явж байгаа гэдгийг хэлье. Харин энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт мөн манай яаман дээр боловсрогдож байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр харин илүү их таатай эцсийн орчныг бүрдүүлж, энэ хуулиудын хоорондын уялдаа нэлээн сайн хангагдаж боловсруулагдаж явж байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Хосбаяр гишүүн хариулт хангалттай юу? Эхний асуултад хариулъя. 6 дугаар микрофон. Эрдэнэс Тавантолгой Сангийн яамнаас хэн

хариулах вэ? Жавхлан сайд хариулах уу? Танайхаас хариуцаж байгаа хүн хэн байна өшөө? Эрдэнэс Тавантолгойтой холбоотой. Байхгүй. Ажлын хэсэг байхгүй. Тодруулъя 5 дугаар микрофон. Юу ч гэсэн Хосбаяр гишүүнээ 5 дугаар микрофонд хариулт өгчихье. Тэгээд та тодруулаад асуу.

Ж.Ганбат: Ер нь энэ тогтоолын гол зорилго нь бид нар төсөв дээр нүүрсээс орж ирэх орлогыг нэмэгдүүлэх зорилгоор биржийн арилжаагаа нэмэгдүүлэх, шинээр орлогын эх үүсвэрийг эрэлхийлэх ийм байдлаар энэ тогтоолын төсөл боловсрогдсон. Энэ тогтоолын төслийг боловсруулахад Эдийн засаг, хөгжлийн яам, Эрдэс баялаг, уул уурхайн яам, “Эрдэнэс Монго”-л энэ тэр хамтарч энийг боловсруулсан. Ерөнхий байдлаар Улсын Их Хурлаас эрхээ аваад тэгээд “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэс Монгол” компани дээр гол энэ зохион байгуулалттай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх юм.

Д.Цогтбаатар: Хосбаяр гишүүний микрофоныг өгье.

Г.Хосбаяр: Энд тодорхой л байгаа юм л даа. Энэ тухайлбал 1 тэрбум ам.долларын үнийн дүнтэй 3-5 удаагийн нүүрсний том арилжааг зохион байгуулж, дэнчин болон эхний төлбөрийн орлогоор 250-350 тэрбум ам.долларыг Монгол Улсад татан төвлөрүүлнэ гээд. Эсвэл энэ худлаа ийм юм биччихсэн юм болов уу? Тэгэхээр яг ийм 250 тэрбум доллар орж ирэх юм уу, ер нь яг ийм том дүнтэй арилжаа зохион байгуулах боломж байгаа юм уу л гэдгийг л асуугаад байгаа юм. Тэгээд хаанах хариулах юм? Би уг нь ингэж мөнгө босгоод мөнгө оруулж ирээд ажил хийхийг дэмждэг хүн байгаа юм. Тэгээд энийг л сонирхоод л лавлаж асуугаад байна л даа. Тэгэхээр Эрдэнэс Тавантолгойд эсвэл тийм боломж байгаа юм уу эсвэл? Сангийн сайд бас хариулт хэлээч.

Д.Цогтбаатар: Сангийн сайдын микрофоныг өгье. Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Харин тийм ээ ер нь бид нар цаг хугацааны хувьд 10-аас хэтрэхгүй дээ цонх хугацаа л байна. Энэ нүүрсний зах зээлийн хувьд. Тийм учраас бидэнд нөгөө баялаг нь байгаад байдаг маш нарийн цонхоор, маш ийм нарийн зам дээгүүр маш хязгаарлагдмал олборлолтын хэмжээнд л бид нар явж чадаж байна. Урд хөрш маань 4, 5, багадаа 5 тэрбумаар тоологдох ийм жилийн хэрэгцээтэй. Ойрын жилүүдэд энэ эрчим хүчнийхээ, нүүрсний эрчим хүчнээсээ шилжилт хийх боломжийг 20 жил гэж ярьж байгаа шүү дээ 20 жил. Тэгэхээр энэ хугацаанд л бид нар цонх хугацаа байгаа юм. Бид энэ цонх хугацаанд тултал экспортлох, үүний зэрэгцээгээр 10-15 жилийн дараа бид дотооддоо тултал боловсруулдаг болчихсон байх ёстой нүүрсээ. Тийм учраас экспортоо нэмэгдүүлэх, ялангуяа нэгэнт бий болчихсон, тодорхой болчихсон энэ.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Жавхлан сайдын микрофоныг гүйцээж өгье.

Б.Жавхлан: Гүйцэлд, эргэлтэд оруулж чадахгүй л байгаад байгаа юм. Тийм учраас энэ Бортээг ч гэдэг юм уу бусад тэр хавьдаа байгаа энэ нөөцүүдээ эргэлтэд оруулах, энийг ширхэглэх биш Улсын Их Хурал дээр танилцуулж, тэндээс зөвшөөрөл авснаар мэдээж биржээр ил тод байдлаар ингэж зарж борлуулж энэ чинь бирж дээр бол спотоос гадна өөр шинж маш олон төрлийн форвард арилжаанууд байна шүү дээ гэх мэтчилэн ийм борлуулах бидэнд маш их боломжууд байгаа. Тэгээд л эргэлтэд оруулъя, Засгийн газар ажлаа хийе,

Үндэсний баялгийнхаа санг арвижуулъя л гэж байгаа ийм л зохицуулалт юм байгаа юм.

Д.Цогтбаатар: Хосбаяр гишүүнд микрофон гүйцээж өгье.

Г.Хосбаяр: Дахиад нөгөө Цогтцэцийгээс Гашуунсухайт хүртэлх концессын авто зам байгаа шүү дээ. Одоо байгаа замын хажуугаар тавьж байгаад дутуу орхичихсон тэр зам бол ноднин Зам, тээврийн сайд Концессын нэрийг нь цуцлаад дахиж хийх гэж байгаа л гээд байсан. Тэр зам юу болж байгаа вэ? Тэр замыг ер нь хурдан тавьж болдоггүй юм уу? Тэгэхгүй нөгөө нүүрс тээврийн бас нарийхан замаар л явж байгаа. Одоо дахиад хажуугаар нь уг нь тэр төр, хувийн хэвшлийн түншлэлийн концессын замаа тавьчихвал нэвтрүүлэх, зөөх хүчин чадал маань нэмэгдэх гээд байдаг. Гэтэл тэр зам бараг 10-аад жил л ингээд л концесс эзэмшигч компани байгаад байдаг. Тэгэхээр энэ дээр ямар арга хэмжээ авагдаж байгаа юм бэ? Энэ зам яг ирэх жил хийгдэх үү? Ер нь концессын гэрээ нь шинэчлэгдэж байгаа юу?

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон. Эдийн засаг, хөгжлийн яам хариулах уу? 6 дугаар микрофон.

Т.Баясгалан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэлх 250км авто замыг “Тал нутгийн хөгжлийн зам” гээд компани концессын гэрээ байгуулаад бариад явж байгаа. Замын хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч компаниас тайлангаа ирүүлж байгаа. Ажлын явцыг 89, 90 хувьтай байгаа гэдэг ийм тайлбарыг өгч байгаа. Таны асууж байгаа асуулт бол Цогтцэцийгээс Гашуунсухайт хүртэлх “Смарт эко транс” компанийн замыг та асууж байх шиг байна. Энэ 19 орчим километр ийм зам байгаа. Тэгээд бид нар яаман дээр надаар ахлуулсан ажлын хэсэг гараад яг одоо “Тал нутгийн хөгжлийн зам”, “Смарт эко транс” компанийн удирдлагуудтай уулзаад ярилцсан. Тэгээд одоо яг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар хамтарсан ажлын хэсэг Зам, тээврийн яамтай хамтарч гараад яг газар дээр нь очиж тэнд үзье гээд бас бид нар явахаар төлөвлөж байна. Тэгээд бас хуулийн ажлууд ингээд давхцаад байгаа манай яг газрын хувьд. Тэгээд яг очиж үзээд бас орон нутаг нь дэмжээд байгаа. Гэхдээ хамгийн тулгамдаж байгаа асуудал.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон гүйцээгээд өгье.

Т.Баясгалан: Хамгийн их тулгамдаж байгаа асуудал “Тал нутгийн хөгжлийн зам”-тай байгуулсан концессын гэрээний заалт байгаа юм. Өөрөөр хэлбэл, тэр концессын гэрээнд энэ компани 250км зам барьж байгаа учраас авто замын зорчих хэсгээс 2 тийшээгээ 50, 50км энэ замуудад дахин авто зам барих тусгай зөвшөөрлийг Монгол Улсын Засгийн газар олгохгүй гээд заачихсан. Тэгэхээр Зам, тээврийн сайдын зүгээс энэ заалтаа эргэж харж үзээч. Засгийн газар танилцуулаач гэдэг санал ирчхээд манай яаман дээр ажлын хэсэг гарчхаад яг энэ концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага яг бодит байдал дээрээ байна уу, үгүй юү? Тэр “Смарт эко транс” компанийн замыг бариулах уу, үгүй юү гэдэг асуудал дээр одоо яг ингээд ажлын хэсэг гарчихсан яг газар дээр нь очиж ажиллахаар ажиллаж байгаа. Тэгээд яг концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна гэдэг асуудал бас нэлээн бас тийм амархан асуудал биш байдаг учраас хөрөнгөө гаргаад барьчихсан “Тал нутгийн хөгжлийн зам” компанийн зүгээс энэ асуудлыг бид дэмжихгүй шүү гэдэг байр сууриа бид нартай уулзахдаа бас илэрхийлсэн байгаа.

Д.Цогтбаатар: Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай. Үг хэлэхгүй. Зарчмын зөрүүтэй саналуудын тухай асуудал орж ирнэ. Тэгэхдээ зарчмын зөрүүтэй саналууд 2 хоногийн өмнө байх өгөгдөх ёстой. Өгөгдөөгүй байгаа. Тэгэхлээр зарчмын зөрүүтэй санал бичгээр өгөгдөөгүй байгаа. Тэгэхээр гаргах угаасаа хугацаа нь тэгэхлээр байхгүй гэсэн үг. Зарчмын зөрүүтэй санал тэгэхлээр байхгүй гэсэн үг.

Төсвийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөлөө. Хэлэлцэх асуудлаа бид нар хэлэлцэж дууслаа. Гишүүддээ баярлалаа.

13.12 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР